

Төслийн мэдээллийн тайлангийн энэхүү орчуулга нь 2017 оны 4-р сарын 10-ны байдлаар ADB.org веб хуудсанд бичигдсэн англи эхэд суурилсан болно.



ASIAN DEVELOPMENT BANK

## Монгол Улс: Сэргээгдэх Эрчим Хүчний Салбарыг Чанаржуулах Төсөл

Төслийн нэр	Сэргээгдэх Эрчим Хүчний Салбарыг Чанаржуулах Төсөл
Төслийн дугаар	50088-002
Төсөл хэрэгжих улс	Монгол Улс
Төслийн төлөв	Санар болгож буй
Төслийн төрөл / Дэмжлэгийн хэлбэр	Зээл
Санхүүжилтийн эх үүсвэр / Мөнгөн дүн	<b>Буцалтгүй тусламж: Сэргээгдэх Эрчим Хүчний Салбарыг Чанаржуулах Төсөл</b> <hr/> Уур амьсгалын стратегийн сан – СЭХДХ 28.50 сая ам доллар <b>Зээл: Сэргээгдэх Эрчим Хүчний Салбарыг Чанаржуулах Төсөл</b> <hr/> Ердийн сангийн эх үүсвэр 100.00 сая ам доллар <hr/> Дэлхийн Банк 11.40 сая ам доллар
Холбогдох стратегийн зорилт	Байгаль орчинд ээлтэй тогтвортой өсөлт Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт
Өөрчлөлтийг чиглүүлэгч салбарууд	Засаглал ба чадавхийн хөгжил Мэдлэгт суурилсан шийдэл Түншлэл
Салбар / Дэд салбар	<b>Эрчим хүч</b> -Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл-газрын гүний дулаан Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл-бага чадлын усан Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл - нарны Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл - салхин
Жендэрийн тэгш эрх ба жендэрийн үзэл баримтлалыг төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь	Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгаагүй

## Төслийн товч агуулга

Төлөвлөж буй төсөл нь (i) Монгол Улсын алслагдмал болон буурай хөгжилтэй бүс нутгуудад хуваарилагдсан сэргээгдэх эрчим хүчний системүүдийг өргөжүүлэх, (ii) Зорилтот газруудад сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэхэд хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсөл удирдах, цахилгаан шугам сүлжээг хянах орон нутгийн цахилгаан түгээх компаниудын чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Төслийг амжилттай хэрэгжүүлснээр жилд 70,000 өрхөд цэвэр цахилгаан түгээж, 82,789 тонн нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтаас сэргийлж чадах юм.

Үүний үр нөлөөгөөр импортын эрчим хүч багасч, эрчим хүчний аюулгүй байдал сайжирна. Төслийн үр дүнд хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлт нэмэгдэх юм. Төслийн дүнд (i) алслагдмал цахилгаан түгээх сүлжээний цахилгаан болон дулааны нийлүүлэлтэд сэргээгдэх эрчим хүчний нөөцийг нэмэлтээр оруулсан байх, ба (ii) хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төслийг удирдах, цахилгаан шугам сүлжээг хянах орон нутгийн цахилгаан түгээх компаниудын чадавхи сайжирсан байх юм.

## Төслийн үндэслэл ба Улс/Бүс нутгийн стратегитэй уялдсан байдал

Монгол Улс одоогоор 969 мегаваттын (МВ) эрчим хүчний нөөц бололцоо бүхий системтэй ч эдийн засгийн ашиглалтын хугацаа нь дууссан буюу хуучирч муудсанаас шалтгаалан зөвхөн 769 МВ эрчим хүч үйлдвэрлэх боломжтой болжээ. Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд эрчим хүчний эрэлт нэмэгдсэнээс ийм хоцрогдсон эрчим хүчний системүүдэд их хэмжээний нэмэлт ачаалал ирж байгаа бөгөөд үүнээс шалтгаалан өндөр үнэтэй импортын эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж байна. 2015 онд нийт эрчим хүчний хэрэглээний 20 хувийг импортолсон байна. Монгол Улсын эрчим хүчний салбар нүүрсээр галладаг дулааны цахилгаан станцууд дээр голлон суурилсан бөгөөд нийт эрчим хүчний нөөц бололцооны 91 хувийг энэ төрлийн эрчим хүч эзэлдэг. Нүүрсээр галладаг станцууд нь нүүрстөрөгчийн давхар ислийн нийт ялгарлын 63 хувийг эзлэх бөгөөд энэ үзүүлэлтээрээ нүүрстөрөгчийн ялгарал өндөр дэлхийн улсуудын дунд тавдугаарт ордог ч Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний асар их нөөц бололцоотой бөгөөр үүгээрээ дотоодын урт хугацааны хэрэглээг хангах боломжтой юм. Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь нь өндөр, төрөлжсөн, хосолмол эрчим хүчний эх үүсвэртэй болох нь өртөг өндөр импортын эрчим хүчний хараат байдлаас гарах болон эрчим хүчний салбар дахь нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулахад чухал ач холбогдолтой юм. Монгол Улсын Засгийн газар 2000 оноос хойш сэргээгдэх эрчим хүчийг түгээн дэлгэрүүлэх тал дээр хэд хэдэн санаачлагыг хэрэгжүүлснээс томоохон ажлуудаас дурдвал: (i) 100,000 гэрийг нарны эрчим хүчээр хангах хөтөлбөрийн (2000-2012) хүрээнд нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийг нарны эрчим хүчээр хангах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн, (ii) "Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль"-ийг баталж, америк долларын нэрлэсэн өртөг бүхий тэтгэх тарифаар зохицуулах, 50 мегаваттын (МВ)-ын чадалтай "Салхит" анхны хувийн салхин цахилгаан станцыг байгуулах ажлуудын эрхүйн

зохицуулалтыг хийсэн. Гэхдээ нийт эрчим хүчний хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь дөнгөж 7.6% байсаар байна. Цахилгаан дамжуулах үндэсний систем нь дөрвөн цахилгаан сүлжээнээс бүрдэх бөгөөд хүн амын 97 хувийг цахилгаанаар хангадаг. Төвийн бүсийн эрчим хүчний систем нь нийт улсын эрчим хүчний хэрэгцээний 90 орчим хувийг хангадаг бөгөөд одоогоор хувийн салбарын 200 мегаваттын хүчин чадалтай сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг татан оролцуулаад байна. Гэвч, алслагдмал болон бүүрай хөгжилтэй бүс нутгуудад байрлах бусад гурван сүлжээ нь эрчим хүчний эрэлт бага, тээврийн зардал өндөр, сэргээгдэх эрчим хүчний нөөц харьцангуй бага зэргээс үүдэн сэргээгдэх эрчим хүчний хувийн салбарын хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй байна. Эдгээр сүлжээ нь тус бүс нутгийн хүн амын 32 хувийг цахилгаанаар хангадаг ба сүүлийн таван жилд цахилгааны эрэлт жилд 10-аас дээш хувиар өсч байна. Алслагдмал газруудад эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх хангалттай хөрөнгө оруулалт байхгүйгаас газар зүйн хувьд тархсан суурин төвүүдийн эрчим хүчний хэрэгцээний 70 хүртэлх хувийг хангахын тулд хөрш орнуудаас эрчим хүч авч импортын эрчим хүчний хараат байдлыг үүсгэж байна. Ингэхдээ цахилгааны урт шугам ашиглан дамжуулдаг тул их хэмжээний цахилгааны алдагдал бий болгодог. Алслагдмал газруудын цахилгаан сүлжээний энэхүү онцгой хүндрэлийг шийдэхийн тулд Засгийн газраас сэргээгдэх эрчим хүчний бололцоог ашигласан анхны эрчим хүчний системийг байгуулахаар зорьж байна. Энэ нь бага оврын болон модульчлагдсан сэргээгдэх эрчим хүчний системээс бүрдэх бөгөөд орон нутгийн хэрэгцээнд зориулан цахилгаан ба дулааны эрчим хүчийг үйлвэрлэж, цахилгаан дамжуулалтын шугамын алдагдлыг бууруулах юм.

<b>Төслийн үр нөлөө</b>	Импортын цахилгааны хэмжээ буурч, эрчим хүчний аюулгүй байдал сайжирна.
<b>Төслийн үр дүн</b>	Хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлт нэмэгдэнэ.
<b>Төслийн үр дүн, үйл ажиллагаа</b>	Алслагдмал цахилгаан түгээх сүлжээний цахилгаан болон дулааны нийлүүлэлтэд сэргээгдэх эрчим хүчний нөөцийг нэмэлтээр оруулсан байх. Хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төслийг удирдах, цахилгааны сүлжээг хянахад орон нутгийн цахилгаан түгээх компаниудын чадавхи сайжирсан байх.
<b>Газарзүйн байршил</b>	

## Хамгааллын бодлогын ангиллууд

Байгаль орчин В

Албадан нүүлгэн шилжүүлэлт С

Уугуул иргэд С

## Байгаль орчин болон нийгмийн асуудлуудын хураангуй

**Байгаль орчин** Урьдчилсан байдлаар төслийн байгаль орчны асуудлыг аюулгүйн арга хэмжээний В төрөлд хамааруулсан. Байгаль орчны шинжилгээ болон менежментийн төлөвлөгөөг 2009 оны "АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичиг" болон Монгол улсын холбогдол хууль, тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

**Албадан нүүлгэн шилжүүлэлт** Урьдчилсан байдлаар төслийн албадан нүүлгэн шилжүүлэлтийн асуудлыг аюулгүйн арга хэмжээний С төрөлд хамааруулсан. Албадан нүүлгэн шилжүүлэлтийн цар хүрээг тогтоож, үүний дагуу байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг үнэлж, аюулгүйн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ингэхдээ "АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичиг" болон Монгол улсын холбогдол хууль, тогтоомжийг мөрдөнө.

**Уугуул иргэд** Урьдчилсан байдлаар төслийн уугуул иргэдийн асуудлыг аюулгүйн арга хэмжээний С төрөлд хамааруулсан. Уугуул иргэдийн төлөвлөлтийн цар хүрээг тогтоож, үүний дагуу хүрээлэн буй орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг үнэлж, аюулгүйн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ингэхдээ "АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичиг" болон Монгол улсын холбогдол хууль, тогтоомжийг мөрдөнө.

## Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба хэлэлцүүлэг

**Төслийн төлөвлөлтийн үед**

**Төслийн хэрэгжилтийн үед**

## Бизнесийн боломжууд

**Зөвлөх үйлчилгээ** Зөвлөх үйлчилгээ нь 2016 оны 11-р сард эхэлж 2018 оны 4-р сар хүртэл 18 сар гаруй хугацаанд үргэлжилнэ. Нийт 28 хүн-сар олон улсын зөвлөх, 65 хүн-сар дотоодын зөвлөхийн үйлчилгээ шаардагдана. Зөвлөх багийг АХБ-ны "Зөвлөх үйлчилгээг ашиглах журам"-ын (2013 онд батлагдаж тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон) дагуу чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулалтын аргаар, чанар-үнийн 90:10-ын харьцааг баримтлан сонгоно. Техник туслалцааны хөрөнгийг "Техник туслалцааны хөрөнгийг зарцуулах тухай АХБ-ны журам" (2015 онд батлагдаж тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон)-д нийцүүлэн зарцуулна.

## Хариуцагч талууд

АХБ-ны хариуцсан ажилтан	Шигэрү Ямамүра
АХБ-ны хариуцсан газар	Зүүн Азийн газар
АХБ-ны хариуцсан хэлтэс	Эрчим хүчний хэлтэс
Хэрэгжүүлэгч байгууллага	<b>Эрчим хүчний яам</b> Засгийн газрын 14 дүгээр байр, Хан-Уул дүүрэг Чингисийн өргөн чөлөө, 3 дугаар хороо Улаанбаатар, 17060 Монгол Улс

## Цагалбар

Концепцийг баталсан огноо	2016 оны 11-р сарын 09
Баримт цуглуулах судалгаа хийгдсэн хугацаа	2017 оны 12-р сарын 11- 22
Удирдлагын хянан хэлэлцэх хурлын огноо	2018 оны 3-р сарын 16
Төсөл батлагдсан огноо	-
Сүүлд хийгдсэн төслийн хяналт	-
Төслийн мэдээллийн тайланг шинэчилсэн	2017 оны 3-р сарын 28

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)-д төсөл, хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл агуулагддаг бөгөөд энэхүү баримт нь байнга шинэчлэгдэж байдаг тул зарим нэг мэдээлэл тайлангийн эхний хувилбарт тусгагдаагүй ч дараагийн хувилбарт орж болно. Санал болгож буй (батлагдаагүй) төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)-г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа баталгааг олгохгүй. АХБ-ны зүгээс агуулгын чанарт ихээхэн анхаардаг хэдий ч энэхүү тайланд агуулагдсан мэдээллийг “байгаагаар нь” буюу арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэнд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүйгээр толилуулж байна. АХБ нь тайлан дахь мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлын талаарх ямар нэгэн баталгаа, эсхүл мэдэгдэл хийгээгүй болно.